

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ

АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Эрдэнэ нуусан ухаан буюу Б. Золбаярын монгол эсээ

Хувилбар А

Нийт 40 оноо

Хугацаа 60 минут

... Монголчууд бид их талын амьд байгалийн дунд тарвалзаж байдаг улс. Тиймдээ ч орон хот, байшин саванд шунамгай, дурламтгай. Гэтэл Европ Америкийн их хотын шуугиант ахуйд төрөгсөд чимээ шуугиангүй, атар онгон байгальд амиа тавьдаг улс.

Б. Золбаярын “Бүгээн”-ийг уншихад аргагүй гоо сайхны мэдрэмжийг сэмлэн, сэтгэл сэртхийлгэж, энэ бүх сайхан сэмрэн урагдаад алга болчих вий дээ гэж шаналгана. Энэ гоо сайхан нь Ховдын Чандманийн, зөвхөн Монголын содон сонин биш, бүр Евро – Азийн нүүдэлчдийн төдийгүй энэ зууны манай цэнхэр өнгөтэй байсан гарагийн маань гоо сайхан болчхоод байгаа юм даа. Тиймдээ ч зөвхөн үүнийг л дэлхийн хүн ардын оюун сэтгэлд хүргэж чадсан тэр монгол зохиолчийг би Нобелийн лекцээ уншина гэдэгт эргэлздэггүй дээ.

Заншил ёс нь байтугай, түүнийг тэмдэглэх үг нь ч алга болох гээд байгаа өнөө үед мартагдаж байгаа ёс заншил, түүнийг тэмдэглэсэн амьд үг хэллэг, чухам үүнийг л Золоо эсээндээ авч үлдсэн нь олзуурхмаар зүйл. Чухамдаа, ардын эрдэнэ нуусан ухаан гэж үүнийг л хэлэх болов уу.

Б. Золбаяр монгол хүний, тэр дундаа малчин монгол хүний бодол ухаарал, ёс заншил, аяг даатхалыг тун нарийн мэдрэмжтэй гаргаж чаджээ. ... Золбаяр тэр гоо сайхныг танин мэдэж, сэтгэл зүрхээрээ хүлээн аваад оносон тохирсон үгээр яв цав илэрхийлэх хосгүй авьяастан лавтай мөн байна.

Үнэндээ өнөөдөр Монголд маань жинхэнэ хөдөөний юм бүхэн илэрхий сарнин алга болж байна шүү дээ. Үүнтэй хамт гоо сайхныг мэдрэх, амтлах монгол хүний мэдрэмж тэр хэмжээгээр л алга болж байна гэсэн үг. Үнэхээр харамсалтай хэрэг.

... Бидний ой санамжаас алдагдчих гээд айлгаад байгаа, нүүдэлчин удмын бидэнд хосгүй үнэтэй тэр л ахуй байдлыг өнөөдрийн дэлхийн уншигчид хүсэн хүлээгээд байх шиг ээ. Малаа маллаад, хайрлаад, бахархаад, өсгөж үржүүлээд, үр шимийг нь хүртээд явна гэдэг монгол хүнд хосгүй гайхамшиг юм даа. Энэ гайхамшигийг маань өнөөгийн хотожсон Монголын залуу үе ойлгохдоо нэг л хөшүүн болчихжээ.

Үнэндээ, нүүдэлчин аж төрөх ёсоо алдана гэдэг монголчуудын хувьд мөхөл сөнөлтэй тэнцэж очих хэцүү хэрэг юм. Үүнийг л ухааруулж чадвал манай ирээдүйн өнгө төрх тодроод ирнэ.

1. “Машинаас бууцгааж, агаар цасны тунгалгийг ам амандаа шагшаад ер бяцхан ч азналгүй оргилыг чиглэн өгслөө.” гэсэн нийлмэл өгүүлбэрийг тодорхойлон энгийн өгүүлбэр болгон бичнэ үү.

/4 оноо/

.....
.....
.....
.....

2. “Б. Золбаярын “Бүгээн”-ийг уншихад аргагүй гоо сайхны мэдрэмжийг сэмлэн, **сэтгэл** сэртхийлгэж, энэ бүх сайхан сэмрэн урагдаад алга болчих вий дээ гэж шаналгана.” Онцолсон үг ямар нөхцөлөөр хувилсан бэ? /4 оноо/

A. Харьяалахын тийн ялгал C. Гарахын тийн ялгал B. Заахын тийн ялгал D. Ямар ч нөхцөлөөр

3. “Тэнгэрээс ах настай уулсын эрх бяцхан ач нар болох энэ толгод салхитай, өвс ногоотой нөхөрлөж, оддод дурлана.” гэсэн өгүүлбэр дэх онцолсон бүтээврийг солин найруулбал аль нь хамгийн тохиромжтой вэ? \4 оноо\

A. –снөө B. –нгөө C. –хлөөр D. –н E. –вөл

4. “нэрлэсэн” хэмээх үгэнд холбогдох зөв бичгийн дүрмийг олоорой. \2 оноо\

A. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагавар залгахдаа зохих балархай эгшгийг ард нь бичнэ.

B. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагавар залгахдаа зохих балархай эгшгийг ард нь бичнэ.

C. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагавар залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ.

D. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд –л дагавар залгахдаа зохих балархай эгшгийг өмнө нь бичнэ.

E. Хэрэв –л дагаврыг залгахад өмнөх балархай эгшиг гээгдэхээр байвал эгшгийг ард нь бичнэ.

5. “насал-“ хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой. \2 оноо\

A. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад эгшгийг хойно нь бичнэ.

B. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад эгшгийг өмнө нь бичнэ.

C. Эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.

D. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ.

E. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад шууд бичнэ

Уран зохиолын даалгавар:

6. Дүрслэх ур маягийг тохирох өгүүлбэртэй нь харгалзуулсныг сонгоорой. \2оноо\

1.Зүйрлэл A.Гунан үхрийн мах идэвч цадахгүй ходоодтой

2.Хүншүүлэл B.Мэлтэлэсэн сүү шиг сарны туяа

3.Хэтрүүлэл C.Хөх усан хормойтой уул минь

A.1C 2A 3B

B.1B 2C 3A

C. 1A 2B 3C

D. 1A 2C 3B

7. Зохиолын дүрүүдийг зөв харгалзуулж сонгоорой \2 оноо\

1.Хөдөө талын үзэсгэлэн A.Би баатар

2.Ламбугайн нулимс B.Гэвш Лодон

3. Учиртай гурван толгой C.Алтан цээж

A.1A 2B 1C

B.1C 2A 2B

C.1A 2B 2C

D. 1B 2A 2C

8. Зохиолыг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. \5оноо\

1. жүжиг а) Д.Цэдэв “Улаан хамбан зодогт буюу тавын даваа”

2. роман б) Д.Нацагдорж “Дөрвөн цаг”

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ

АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТ

Хувилбар В

Хугацаа 60 минут

Нийт 40 оноо

Газрын юм

Хүнийг хоёр ээжтэй гэвэл нэг нь хойд эх юм уу өргөж авсан ээж нь юм байх гэж бодогддог. Гэтэл энэ хорвоод төрж мэндэлсэн хэн гуай ч гэсэн хоёр ээжтэй нь гарцаагүй болно. Нэг дэх ээж нь тээж төрүүлсэн ээж. Түүнтэй маргах хэн ч үгүй. Хоёр дахь ээж нь газар юм гэвэл төрөхөд эх барьж авсан “газар ээжийг” хэлж байна хэмээн бодох биз. Гэвч биш. Жинхэнэ хөрс шороот газрыг хүний хоёр дахь ээж гэж хэлэх санаатай байгааг маань болгооно буй заа. Яагаад хүн бүрийн хоёр дахь ээж хэн бэ гэвэл:

Нэг. Газрын шүүсийг ууж хүн хүн болдог /ус уухаас эхлээд/

Хоёр. Газрын шимийг хүртэж хүн хүн болдог /талх идэхээс эхлээд/

Гурав. Газрын гүйдлийг дагаж хүн хүн болдог /цахилгаан соронзон орон зайд/

Дөрөв. Газрын татах хүчийг түшиж хүн хүн болдог /хөдөлгөөний тэнцвэр олж гэйх харайхаас эхлээд/

Тав. Газрын амьсгааг шүтэж хүн хүн болдог /цаг уурын эрхшээлээс эхлээд/

Зургаа. Газрын хишгийг авч хүн хүн болдог /мөөг жимснээс эхлээд алт, мөнгө, зэс, төмөр хүртэл/

Газраас юм авахгүйгээр хүн хүн болохгүй нь бичигдээгүй хууль. Газар бидэнд бүхнийг өгнө. Тэр ч байтугай сэтгэл санаа, зан суртахууныг өгнө. Уулын хүн урт настай ч цочмог зантай байх. Тал газрын хүн тайван уужим зантай ч идэвх дутмаг байх. Ойн иргэд зоригтой ч хардамтгай байх... гэхчлэн хүрээлэн буй орчноос юу эсийг хүн олж авдаг гэх вэ? Сайнаас гадна саарыг ч авч мэднэ. Газар усны хорлол болно, лус хилэгнүүлчих нь гэж өвгөд дээдэс маань залгамжлуулан захиж гэрээсэлсэн нь учиртай. Гар дээр юм гарчихвал газрын юм гэж ярьдаг нь ч дэмий үг биш. Газарт шүтэж амьд явдаг нь ганц хүн биш. Газарт бүхий л төрлийн амьд амьтан бүгж, орогнож амьдарна. Газарт шороон түмэн нян хорхойноос эхлээд үлэмж биетэн ч шүглэсэн байдаг. Газраас цахилгаан болон соронзон гүйдэл, цацраг туяа хүртэл түгдэг. Газрын илч гэж буй. Газрын жавар ч гэж бас бий. Тэр бүхэн нь хүнд нөлөөлж насан туршид нь дагалдана.

Дундговийнхон дууч байдаг шиг Увсынхан туульч, Хөвсгөлийнхөн бөөч, Дарьгангынхан хэлэмгий байдаг нь юуных вэ?

Шил дээр ургасан шийжүү будаа

Шимтэй байдаг нь юуных вэ? гэж дуулдаг маань явдалтай.

Хүний бие бялдар, сэтгэл санаа, эрүүл мэнд, авьяас билигт газар зүй, хүрээлэн буй орчны нөлөө тооцох аргагүй нарийн байдаг. Түүнийг харгалзан тооцох талаар өнөөг хүртэл ухаан дутаж, ухаарал хомсодсоор байгаагийн балгаар хүний болоод нийгмийн амьдралын олон үзэгдэл юмс өөрөөр шийдэгдэх, хазгай гишгэх магадлал өндөр хэвээрээ л байна.

Газрын юм” гэдэг аугаа нарийн, аугаа нууц, аугаа гүнзгий юм шүү.

Учыг эргэцүүлэхийн үүднээс соронзон хүчдэлийн талаар энгийн үгээр зарим ойлголтыг хойно дурдъя.

Манай бөмбөрцгийн гадаргуу нь нэлдээ соронзон талбай юм. ...Тийнхүү дэлхийн соронзон мандал тогтоод соронзон хүчдэлийн тайван байдал соронзон хүчдэлийн тавгүй байдал гэдэг хоёр туйлынхаа хооронд хэлбэлзэж, тэр нь хорвоо дээр аж төрдөг амьтай бүхэнд, урган цэцэглэдэг ургамал бүхэнд хамааралтай байдаг ажээ. Дэлхийн аль ч хязгаарт байсан ялгалгүй соронзон луужингийн зүү нь дэлхийн соронзон уртрагийн дагуу умар, өмнийг алдахгүй заадаг нь гео соронзон талбайн чиглэл буюу бөмбөрцгийн болзолт хавтгайтай тохирч байдаг юм.

Тэрчлэнгээр өвс ургамалд болон адгуусан амьтдад соронзон талбайн нөлөө маш нарийн хэмжүүрээр тодорхойлогддог ажээ. Нөгөөтэйгүүр, соронзон гажиг бүхий газар орон нь тэнд аж төрдөг хүмүүс болон ургамал амьтдад сайн болоод саар нөлөөтэй байдгийг нэгэнт шинжлэн судалсан ажээ.

Ямар ч байлаа гэсэн газрын соронзон мандал нь зөвхөн газраас өөрөөс нь хамааралтайгаар барахгүй сансрын жолоодлоготой нарийн тогтолцоо юм. Хүн гэдэг түүний үл ойлгогдох, басхүү үл захирагдах нууцгай эргүүлэг дунд төрж өсөөд, өтөлж өнгөрдөг болохоор хүрээлэн буй үл үзэгдэх тэр хүчин зүйлийг танин мэдэж зохилдон аж төрөх нь өлзийтэй шийдэл болох билээ.

1. Дараах өгүүлбэрийн тодруулсан үгийг угсруулан холбох нөхцөлөөр солин найруулж бичнэ үү. \4 оноо\

Хэд хэдэн салбарын хэдэн зуун ном туурвиж, гучаад хэлээр нэг сая таван түмэн ширхэгээр хэвлүүлсэн бичгийн хүний үзэг уяа нь таарсан хүлэг адил...

.....
.....
.....
.....

2. “Гэвч биш. Жинхэнэ буй заа.” гэсэн өгүүлбэрт орсон холбох үгийн үүргийг олоорой. (4 оноо)

А. Лавшруулан холбох В. Онцлон холбох С. Зэрэгцүүлэн холбох D. Эсрэгцүүлэн холбох

3. “Газарт бүхий л төрлийн амьд амьтан бүгж, орогнож амьдарна. Газарт шороон түмэн нян хорхойноос эхлээд үлэмж биетэн ч шүглэсэн байдаг.” гэсэн өгүүлбэрийн онцолсон бүтээврийн үүргийг тодорхойлоорой. (4 оноо)

А. Зэрэгцүүлэн онцлох В. Салган онцлох С. Магадлан онцлох D. Батлан онцлох

4. “гүзээлье” хэмээх үгэнд холбогдох зөв бичгийн дүрмийг олоорой. \2 оноо\

А. Зөөлний тэмдгийн дараа е орвол зөөлний тэмдэг хэвээр байна.

В. Зөөлний тэмдгээр төгссөн эм үгэнд е эгшгийг шууд залгаж бичнэ.

С. Эм үгэнд е эгшиг өмнөх гийгүүлэгчээсээ саланги дуудагдахаар орвол зөөлний тэмдгээр тусгаарлаж бичнэ.

Д. Заримдаг гийгүүлэгчийг зөөлрүүлсэн зөөлний тэмдгийн дараа е орвол зөөлний тэмдэг хэвээр байна.

Е. Зөөлний тэмдгийн дараа туслах эгшиг е орвол зөөлний тэмдгийг хэвээр бичнэ.

5. “нэрлэсэн” хэмээх үгэнд холбогдох зөв бичгийн дүрмийг олоорой. \2 оноо\

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар С

Хугацаа 60 минут

Нийт 40 оноо

Толгод

Үдшийн цагт тэнгэр толгодод сарны туяаг шившин оруулна. Гараг оддын аялгуу толгодоос эгшиглэн, нөмөрт нь хоргодоом толгод эртний сайхан нөхөд мэт дотно. Энэ бяцхан толгод хэзээ нэгэн цагт уулс болно доо гэж бодном. Толгод хүүхэд адил өсөж, толгод хүүхэд адил олширч, үдшийн цагаан гэгээнд хөөцөлдөн эрхлэлдэхийг ажигуй энэ яваа насны учир утга, амьдрахуйн хүслэн тодорно. Тэнгэрээс ах настай уулсын эрх бяцхан ач нар болох энэ толгод салхитай, өвс ногоотой нөхөрлөж, одод дурлана.

Намрын үдэш олон бор толгодын дунд даарсан янзага надад бяцхан дүүг минь санагдуулна. Алгаа тосоор дөхөхөд айсан нүд нь гэм зэмгүйн бэлгэдэл тэр жаахан амьтан холдосхийнэ. Толгод, янзага хоёр ихэр юм шиг санагдана. Хорин жилийн өмнөх ертөнц нүдний өмнө тодорч, эмээ минь толгодын оройд үлгэр шивнэн суух шиг.

Толгод, өвс ногоо, янзага, эмээ, салхи, бид зургаа нэгэн үлгэр болж, сарны туяанд олон толгод амилан, олон цагаан ботго гунганах шиг...

Үлгэр, үнэн хоёр сүлэрч, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусаж, тархи толгойд минь одод бужигнан орж ирж, би өөрөө үгүй, хязгааргүй орон зай, тэнгэр, одод, толгодтой нэгдсэн мэт санагдана. Аажмаар энэ тансаг үлгэр минь тэнгэрт замхарч, бие жихүүцнэ. Бага насны үлгэрийн диваажингаас эргэж ирэхдээ жигтэйхэн эмзэглэж, “Толгодын тоогоор шүлэг бичих сэн” гэж адгана.. толгод бүхэн эх орноо хайрлах сэтгэлийн эрх юм. Сарны туяа шингэсэн толгоддоо би хорвоогийн жамаар очиж, толгодоос минь гараг оддын аялгуу эгшиглэх тоолон орчлонгийн хязгааргүйд би шингэнэ. Ийнхүү би шүлэглэнэм.

О.Дашбалбар

1. Угсруулах холбоо бүхий УНӨ –ийг олж бичээд тодорхойлоорой. 4 оноо

.....
.....
.....

2. “Алтан Богдын шилд

Алтан гургалдай жиргэнэ.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үгийн утгыг олоорой. \4 оноо\

- А. Уулын хажуугийн налуу шувтрах газар В. Уулын бэрх цухал гүн жалга С.Уул хярын дээд ирмэг D. Уулын толгодын арын нам хотос газар Е. Уулын хярын өвөр газар

3. Эхээс зэрэгцүүлэх болон угсруулах үүрэгтэй орсон 1,1 бүтээврийг ялган үүргийг тодорхойлоорой. \4 оноо\

.....
.....

4. “уутал-” хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой.\ 2оноо\

- А. Эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.
В. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ.
С. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх -л дагавар залгахад шууд бичнэ.

D. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх –л дагавар залгахад эгшгийг өмнө нь бичнэ.

E. Үгийн дунд орсон ялгах эгшгийг гээдэггүй.

5. “**бодохоос**” хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой. \2 оноо\

A. ж, ч, ш-ээс бусад гийгүүлэгчийн дараа орсон “и” эгшгийг гээхгүй.

B. Эгшгээр төгссөн үгэнд урт эгшгээр эхэлсэн залгавар залгахад эцсийн богино эгшгийг гээнэ.

C. Эгшигт гийгүүлэгч эгшиггүй болоход хүрвэл богино эгшгийг гээхгүй.

D. Цагт нэрийн -х дагаврын өмнөх богино эгшгийг гээхгүй.

E. Заримдаг гийгүүлэгчийг эгшиггүй бичиж болно.

Уран зохиолын даалгавар:

6. МНТ-ны дараах шүлэгт сэтгэл хөдлөлийн ямар өнгө аясыг илэрхийлсэн бэ? \2 оноо\

“...Хохимой муу толгойгоо

Хоргодох газаргүй болгов

Хорголын төдий амиа

Арчлах газаргүй болгов

A. Гэмшсэн B. Гомдсон C. Цөхөрсөн D. Уйдсан

7. Онолын зөв тодорхойлолтыг олоорой. \2 оноо\

Уран зохиолын бүтээлд уран дүрийн түвшинд боловсруулсан, уран сайханжсан баримтат дүрийггэнэ.

A. Уран сайхны дүр

B. Түүхэн дүр

C. Баримтат дүр

D. Гол дүр

8. Д.Равжаагийн “Үлэмжийн чанар” дуулалд хүний таван мэдрэхүйг илэрхийлсэн дүрслэлүүдийг зөв харгалзуулсан хэсгийг олоорой. \5 оноо\

1. Харах

A. Хөхөө шувууны эгшиг шиг

A. 1a 2b 3c 4d 5e

2. Сонсох

B. Хүсэлт тэнгэрийн эдлэл мэт

B. 1c 2b 3a 4e 5d

3. Үнэрлэх

C. Өнгө тунамал толь шиг

C. 1c 2a 3d 4e 5b

4. Амтлах

D. Улаан занданы үнэр шиг

D. 1b 2d 3c 4a 5e

5. Хүрэлцэх

E. Балын амт адил

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар D

Хугацаа 60 минут

Нийт 40 оноо

Зөв амьдрахуй

Зөв амьдрахуй гурван ёсонд буюу:

Үзэмжит эдийг биедээ “агсах” нь атаанд баригдахын даллага тул бусдын нүд асаах хэт хээнцэр гоёмсогт нэрмэгдэхгүй, бор жирд ханах лугаа нэг,

Үхээнц доройд угнагдах нь адаг шаагдахын даллага тул бусдын доромж дээрэнгүйг нэрдээ үл халдаах хэтий эрдэм чадалд ноён суух лугаа хоёр,

Өвдөх хийгээд зовох нь насанд үл хүсэгдэх гаслан тул биедээ өвчин хуучгүй, сэтгэлдээ гэмээнэ хийснээ чамлах, хэмжээ хэрийн нь багад адган харуусахаас өөр гэмшил, зовиургүйгээр амьдын далайг гэтлэх лугаа гурав болой.

Магтаал шагнал болгон нэхэлтэй байдаг. Сэтгэлийн өр, хийх зүйлийн урьдчилгаа гэдгийг эс мартагч тул шагнал болгон айдас “унаж ” ирдэг.

/Б. Лхагвасүрэн/

1. Эргэн тойрон эгц эгц өндөр ханан хад сүндэрдэж хавцал гол хоёрын хоорондох нарийн жим улам нарийсаж, дээр хөх тэнгэр л мэлтийнэ.гэсэн өгүүлбэрийн холбох нөхцөлийг солин найруулж бичээрэй 4 оноо
.....
.....
.....
2. “Үлгэр үнэн хоёр **сүлэрч**, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусна.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үйл үгийн утгыг олоорой. \4 оноо\
А. нийлэх В. сарних С. замхрах D. холилдох E. шингэх
3. “Ардын дууны утга сая тайлагда**Ж**, мартагдахын их далайг туулж ирсэн увдис нь бишрэл төрүүлнэ.” Гэсэн өгүүлбэр дэх онцолсон бүтээврийг солин найруулбал аль нь хамгийн тохиромжтой вэ? \4 оноо\
А. –вал В. –нгаа С. –хлаар D. –снаа E. –н
4. “эмзэглэ-“ хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой. \2 оноо\
А. Эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.
В. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-Л” дагавар залгахад эгшгийг хойно нь бичнэ.
С. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ.
D. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-Л” дагавар залгахад шууд бичнэ.
E. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-Л” дагавр залгахад эгшгийг өмнө нь бичнэ.
5. Буруу бичсэн бүлэг үгсийг олоорой. \2 оноо\
А. харагдснаас, маллаа, авчихаад В. харчхаад, эмээллэлээ, товчилвол

С. хүргээнэ, моджино, олгочхоосой

D. түлхэхээр, түүхчдийг, нөхцөлөөр

Е. өгүүлбэрийг, уулзалтанд, тооцуулашгүй

Уран зохиолын даалгавар:

6. Аман зохиолын жишээг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. \5 оноо\

a. бэлгэ дэмбэрлийн үг

1. Жавартай тэнгэрийн хаяа нэг улаан

Жаргалтай хатны хацар нэг улаан

Жалганд ургасан сухай нэг улаан

b. мялаалгын үг

2. Сааль нь арвин байг

Саальчин нь мөнх наслаг

c. зүйр цэцэн үг

3. Ган зуднаас хамгаалдаг

Галт хар үнэгтэй

Гайхам сайхан Алтай минь

d. магтаал

4. Найлзуурыг засах нуруу болгодог

Нялхыг өсгөж эр болгодог

e. ертөнцийн гурав

5. Урд хормой дээр чинь унага даага

Хойд хормой дээр нь хонь хурга гишгэг

7. Цав цагаан үүл

Хаш цагаан үүл

Цааш нааш давхцаж

Сүлжиж ороон тогтоод

Цаадах хөх огторгуйд

Цасан угалз болж

Цагаан луу хээтэй

Хөх торгоны адил. (Ц.Дамдинсүрэн)

Шүлгийн тодруулсан мөрд ямар дүрслэх хэрэглүүр илэрсэн бэ? \2 оноо\

A. Егөөдөл

B. Төлөөлөл

C. Хүншүүлэл

D. Юмшуулал

E. Зүйрлэл

8. “Баруун талаар нь тойроод харахад

Балар харанхуй модтой

Баттай зэндмэнэ эрдэнэ

Баялаг болгон түгсэн

Баахан олондоо алдартай

Баян буурал Алтай минь” гэсэн нь аман зохиолын ямар төрөл вэ? \2 оноо\

A. Бэлгэ дэмбэрлийн үг

B. Цэцэн үг

C. Ереөл

D. Магтаал

E. Хэл зүгшрүүлэх

үг

9. Үндэсний бичгийн даалгавар:

“ШИНЭ ХӨГЖИЛ” СУРГУУЛИЙН 10 ДУГААР АНГИЙН МОНГОЛ ХЭЛНИЙ
АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН СЭДЭВ

Хувилбар Е

Хугацаа 60 минут

Нийт 40 оноо

Залхуурал

Хүн сурч мэдэх, өсөж өөдлөхөд хамгийн хорлонтой дайсан нь залхуурал. Залхуу хүн цаг хугацааны үнэ цэнийн талаар туйлын бага төсөөлөлтэй. Хойш тавих, зүгээр суух, сугарч хоцрох, биеийн амрыг харах тэдний хувьд амьдралынх нь утга учир мэт. Тэгээд ч ухаант өвгөд “Залхуу хүнд маргааш олон” гэж шоглон, үүнийг ялж дийлэхгүйгээр заяа тэгш явна гэж үгүй. Залхуу хүн ямагт сэтгэл дутуутай байдаг.

Сэтгэлийн дутууг ялж нөхөхгүйгээр амжилт ололт, төгс төгөлдөр, сайн зүйлийн тухай мөрөөдөөд ч хэрэггүй. Сэтгэл дутсан, нүд хуурсан, ээлж өнгөрөөсөн юм бүхэн урам насгүй, сайнаар хэлэгдэхгүй тийм болохоор

Монголчууд “Сэтгэлд гал байвал, зууханд аргал олдоно” хэмээн ярьж, хэрэгжүүлж байдаг юм.

1. “Алтан гургалдайн жиргэх дуун сая сэтгэлийн гүнд хүрнэ.” гэсэн өгүүлбэрийн хэв шинжийг тодорхойлоорой. \4 оноо\

A. Зэрэгцсэн нийлмэл өгүүлбэр

B. Харилцан угсарсан нийлмэл өгүүлбэр

C. Угсарсан нийлмэл өгүүлбэр

D. Энгийн өгүүлбэр

2. “Үлгэр үнэн хоёр **сүлэрч**, санаа бодол дээд цэгтээ хүртэл ариусна.” гэсэн өгүүлбэрийн онцолсон үйл үгийн утгыг олоорой. \4 оноо\

A. нийлэх

B. сарних

C. замхрах

D. холилдох

E.

шингэх

3. “Тэнгэрээс ах настай уулсын эрх бяцхан ач нар болох энэ толгод салхитай, өвс ногоотой нөхөрлөж, оддод дурлана.” гэсэн өгүүлбэр дэх онцолсон бүтээврийг солин найруулбал аль нь хамгийн тохиромжтой вэ? \4 оноо\

A. –снөө

B. –нгөө

C. –хлөөр

D. –н

E. –вөл

4. “**насал-**“ хэмээх үгийн зөв бичих дүрмийн тайлбарыг олоорой. \2 оноо\

A. Эгшигт гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад эгшгийг хойно нь бичнэ.

B. Заримдаг гийгүүлэгчээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад эгшгийг өмнө нь бичнэ.

C. Эгшигт гийгүүлэгч аль тод хэлэгдэх талдаа заавал эгшигтэй бичигдэнэ.

D. Заримдаг гийгүүлэгчийн дараа заримдаг гийгүүлэгч ороход заавал эгшигтэй бичигдэнэ.

E. Эгшгээр төгссөн үгэнд үйл үг бүтээх “-л” дагавар залгахад шууд бичнэ.

5. Буруу бичсэн бүлэг үгийг олоорой. \2оноо\

A. орчихоод, эргэчихбэл, тугаллаа

B. биччихийг, туслахаар, төрөлхтнөөр

C. иулгамдсанаас, шагалзахыг, үзьюү

- D. бузардсанаар, олонхи, хуулчхыг
E. баримтнаас, хэвлэгдсэнийг, урсжээ

Уран зохиолын даалгавар:

6. Аман зохиолын жишээг төрөл зүйлтэй нь зөв харгалзуулаарай. \5 оноо \

- | | |
|------------------|------------------------------------------------------------------------------------------|
| a. зүйр цэцэн үг | 1. Хамба торго хээгүй
Ханчин сувд нүхгүй. |
| b. магтаал | 2. Харуулын ирээр өөлж хийсэн
Хамаг амьтныг хашиж тогтоосон
Хаалга түүнийг мялаая. |
| c. ерөөл | 3. Хөөрхөн халиун долгин шүү
Хөлд нь сууж бариарай. |
| d. ардын дуу | 4. Жаран хоёр соёотой
Хүдэр хүрэн шинжтэй
Баян буурал Алтай дэлхий. |
| e. оньсого | 5. Буурлаас үг сонс.
Болсноос ам хүр. |

7. Зохиолын дүрүүдийг зөв харгалзуулж сонгоорой. \2 оноо\

- | | | | |
|--------------------------|--------------|------------|-------------|
| 1. Хөдөө талын үзэсгэлэн | A.Би баатар | | |
| 2. Ламбугайн нулимс | B.Гэвш Лодон | | |
| 3. Учиртай гурван толгой | C.Алтан цээж | | |
| A.1A 2B 1C | B.1C 2A 2B | C.1A 2B 2C | D. 1B 2A 2C |

8.Бүтээлүүдийг зохиогчтой харгалзуулж сонгоорой. \2 оноо\

- | | | | |
|-----------------------------------------|----------------|--------------|-------------|
| 1.Жамухын өчил | A.Ж.Саруулбуян | | |
| 2. Бодончар богд | B.Д.Цэдэв | | |
| 3. Улаан хамбан зодогт буюу тавын даваа | C.Д.Намсрай | | |
| A.1B 2C 3A | B.1C 2B 3A | C.1 A 2C 3 B | D. 1A 2B 3C |

Үндэсний бичгийн даалгавар:

1. Дараах эхийг уншаад кирил бичигт хөрвүүлээрэй. Үгийн тоо 25. 0-1 алдвал 5 оноо, 2-4 алдвал 4 оноо, 5-7 алдвал 3 оноо, 8-10 алдвал 2 оноо, 11-13 алдвал 1 оноо, 14-өөс дээш алдвал 0 оноотой болно. [5 оноо]

